

## ТАГНА, САЯНЫ НУТГААР ТАВ ХОНОГ АЯЛСАН НЬ

*Д.Шүрхүү\**

2002 оны 8-р сарын дундуур Монгол улсын Их хурлын гишүүн, энэ үед ШУА-ийн ерөнхийлөгч байсан Б.Чадраа гуай яаралтай ирж уулз гэсний дагуу ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар очлоо. Миний бие Олон улс судлалын хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн даргын алба хашдгийн хувьд дээд удирдлагаас ажил хэргийн шугамаар ямар нэг үүрэг даалгавар өгөх гэж дуудсан болов уу хэмээн бодсоор Б.Чадраа гуайн өрөөнд орлоо. Харин Б.Чадраа ерөнхийлөгч, би Тувагийн Засгийн газрын дарга Ш.Д.Ооржакийн урилгаар 2002 оны 8-р сарын 14-19-нд Тувад айлчлах гэж байна, чи Монгол-Тувагийн харилцаагаар эрдмийн зэрэг хамгаалсан хүний хувьд Тувагийн өнөөгийн байдлыг хэр зэрэг судалж байна, айлчлалд зориулан гарын авлага болохуйц тодорхой мэдээлэл бэлтгээд ир гэсэн даалгавар өглөө. Хоёр хоногийн дотор өөрийн диссертаци зохиол, судалгааны ном хэвлэл, интернетээс авсан мэдээллүүдээ нэгтгэн лавлах материалууд бэлдэн 8-р сарын 13-ны үдээс хойш Б.Чадраа гуайд танилцуулахад, тэрбээр Ч.Авдай гишүүн надтай хамт уригдсан боловч яаралтай ажил хэргийн улмаас явж чадахгүй болоод байна. Чи судлаач хүний хувьд надтай хамт маргааш Увс руу нисч, Тувагийн баяр наадам, өнөөгийн байдлыг өөрийн биеэр үзвэл зүгээр, боломж байна уу хэмээн асуулаа. Хэрэв Улаанбаатар-Улаангомын онгоцны билет олдвол бараг болох байх, маргааш өглөө паспортоо мөн сунгуулна гэдгээ хэллээ. Энэхэн зуур надад хамгийн анх Тувад 1994 оны намар тэр үеийн нэрээр Тувагийн Түүх, Хэл, Утга зохиолын хүрээлэнгийн урилгаар 14 хоног ажилласнаас хойш Тува хэр зэрэг өөрчлөгдсөнийг үзэх сонирхол төрөхийн хамт, архивын хуудсанд манай албан ёсны төлөөлөгчид Тувагийн баяр наадамд уригдан оролцож байсан тухай уншиж байснаас өөрийн биеэр оролцоно хэмээн бодож байгаагүй тул бүр ч сонин санагдаж өөрийн эрхгүй яарах сэтгэл төрж байлаа.

Үнэндээ Тува орох хамгийн хүнд асуудал бол тээврийн асуудал бөгөөд дэлхийн аль ч өншгөөс хамгийн алслагдсан нутаг бөгөөд цөөхөн нислэг хийдэг ЯК-40 онгоцыг эс тооцвол автомашинаас бусад тээврийн хэрэгслээр шууд очих боломжгүй буйдхан газар юм. Гэхдээ энэ нь

\* Д.Шүрхүү - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Тувагийн онгон байгаль, газар нутаг, уугуул иргэдийн үндэс угсаа, хэл соёлоо хадгалан үлдэх өвөрмөц дархлаа болж байсныг үгүйсгэх аргагүй билээ.

Б.Чадраа гуай бид хоёр 2002 оны 8-р сарын 14-ны 12.00 цагт Тува орохоор Улаанбаатараас Улаангом хүртэл онгоцоор ниссэн бөгөөд Улаангом дээр манай улсаас Тувад сууж буй консул Д.Пунцаг, консулын туслах Дагмид нар угтан авч Боршоо-Хандгайтын боомт руу явав. Боршоо-Хандгайтын боомт дээр Тувагийн Боловсон хүчний яамны сайд хатагтай Ондар.Л.Ш, Гадаад хөрөнгө оруулалт, гадаад эдийн засгийн яамны дэд сайд хатагтай Н.Ч.Дариймаа, тус яамны ажилтан залуу Мэргэн нар угтан авч Кызыл хүртэл 400 орчим км урт замыг дагалдан явж туулав. Тува Зочид буудлын хувьд ч мөн адил Кызылдээ тохь тух, орчныхоо тохижилтоор нэлээд дээгүүрт ордог, гол төлөв гадаадынхан байрладаг Өдүгэн хэмээх зочид буудалд дахин буув. Эхний өдрийн сэтгэгдлээс өнгөц харахад Тувад төдийлөн гойд өөрчлөлт гараагүй, бүх зүйл хэвээр байгаа мэт санагдаж байлаа. Яг 8 жилийн өмнө Түүхийн хүрээлэнгийн доктор Болд гуайн хамт Хандгайтын боомтоос Кызыл хүртэл энэ замыг туулсан юм. Тэр үед биднийг Тувагийн нэртэй түүхч, археологич М.Х.Маннай-оол гуай тосон авч дагалдан явж байлаа. Гэхдээ бодит байдал дээр Тувагийн нийгэм, улс төр эдийн засагт ОХУ-д гарч буй өөрчлөлт хувьсал өөрчлөлт тусгалаа олсон байлаа.

2002 оны 8-р сарын 15-ны өдөр ОХУ-ын Бүгд Найрамдах Тыва (Тува) улсын Засгийн газрын дарга Ш.Д.Ооржак Засгийн газрын ордондоо Монгол улсын Их хурлын гишүүн, ШУА-ийн ерөнхийлөгч Б.Чадраа тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзан элэгсэг дотно ярилцаж, харилцаа хамтын ажиллагааны талаар санал солилцов. Уулзалтын эхэнд ноён Ш.Д.Ооржак урилгыг хүлээн авч Тувад зочилж, тус улсын баяр наадамд оролцохоор ирсэнд талархлаа илэрхийлээд Тувагийн түүхэн хөгжлөөс товч ярив. Ноён Ооржак Тува, Монголын түүхэнд нийтлэг зүйл нэлээд бий бөгөөд скифийн, сарматын, монголын эзэнт гүрний, манж гүрний үе гэх мэт түүхэн урт хугацааг туулах явцад тува хэмээх этнос бүрэлдэн тогтсон юм. Тува, Монгол хоёр манжийн дарлалаас чөлөөлөгдсөний дараа бие даасан хөгжлийн замд орсон билээ.

Орос орны ардчилал 1985 оноос эхтэй, түүний үндэс суурийг тавьсан хүн бол М.С.Горбачёв юм. Зөвлөлт засгийн үеийг ихээхэн шүүмжилдэг боловч Тувад их зүйлийг хийж бүтээсний дотор 246 үйлдвэр аж ахуйн газрыг барьж байгуулсан юм. Н.Хрушевийн үед Тувад

нэлээд их анхаарал тавьж олон тооны тогтоол шийдвэр гарч байлаа. Б.Ельцин 1994 онд Тувад зочилсон нь түүхэнд анх удаа Орос орны тэргүүн тува нутагт зочилсон түүхэн үйл явдал болсон ба Б.Ельцин Тувад Як-40 онгоц, бүх хошуунд автомашин бэлэглэснээс гадна нийгмийн хамгааллын талаар хэд хэдэн чухал арга хэмжээ авсан билээ. В.В.Путин ОХУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдсоноос хойш Тувагийн нийгэм эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлтийг түргэтгэн хөгжүүлэх, ялангуяа боловсон хүчин бэлтгэх, усан тээврийг хөгжүүлэх гэх мэт олон асуудлаар тогтоол шийдвэр гарган одоо хэрэгжүүлж байна.

Эдүгээ Тувад улс төрийн 25 нам, хөдөлгөөн, 26 олон нийтийн байгууллага, үйл ажиллагаагаа явуулж, 46 сонин хэвлэл хэвлэгдэж байна. 2001 оны 6-р сард бүх нийтийн санал асуулгаар Тувагийн шинэ Үндсэн хуулийг батласан юм. Энэ нь Тувагийн өмнөх Үндсэн хууль ОХУ-ынхтай зарим талаар зөрөлдөж байсныг арилгасан юм.

Тувагийн эдийн засагт хөдөө аж ахуй, түүний дотор нүүдлийн мал аж ахуй зонхилдог юм. Үндсэн фондын 88% хувийн хэвшилд оногдож байгаа ба улсын 100 үйлдвэр аж ахуйн газар ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд соёл, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэндийн салбар сэргэн хөгжиж байна. Тувад 9 их дээд сургууль, нэлээд хэдэн эрдэм шинжилгээний хүрээлэн, төвүүд ажиллаж байна.

Монгол улс бол Тувагийн эдийн засгийн гадаад харилцаанд нэн чухал ач холбогдол бүхий хөрш орон тул бид энэ талын харилцааг хөгжүүлэх хүсэл эрмэлзэл их байна. Юуны өмнө хил орчмын аймгууд Ховд, Завхан, Увстай нягт хамтран ажиллах хэрэгтэй, хамтын ажиллагаа ч мулгүй хөгжиж байна. Эдгээр аймгуудтай хамтран ажиллах тухай гэрээнүүд байгуулж, 80 гаруй үйлдвэр аж ахуйн газар ямар нэг хэлбэрээр харилцаа тогтоогоод байна. Хил орчмын харилцааг хөгжүүлэхэд дэд бүтэц, зам харилцаа дамжин өнгөрөх боомтууд чухал үүрэгтэй. Манай талаас үүнд ихээхэн анхаарал тавьж байгаа ба одоо байнгын ажиллагаатай боомт Хандгайтыг цагт 100 автомашин, Цагаан толгойг-50 автомашин, Шар суурийг- 25 автомашин дамжин өнгөрүүлэх чадалтай болгон өргөтгөн шинэчлээд байна. Ойрын үед Эрзин-Цагаан толгойн засмал замыг барьж дуусгана. Мөн түүнчлэн Баян-Өлгий аймагтай харилцахад чиглэсэн Улаандаваагийн хилийн боомтыг нээх боломжийг судалж байна. Монголоос манайд 25 оюутан эмч, багш зэрэг янз бүрийн чиглэлээр суралцаж байна. Цаашид хоёр орны харилцаа хамтын ажиллагааг улам эрчимжүүлэхийн тулд хамтарсан томоохон төслүүд, тухайлбал технопарк байгуулах, чөлөөт худалдааны бүс байгуулах, хамтын ажиллагаа хөгжүүлэх,

интеграцчлах урт болон дунд хугацааны хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж болох юм. Ноён Ш.Д.Ооржак ярианыхаа төгсгөлд хүндэт зочдыг Тува нутагт тавтай сайхан зочлохыг хүсэв.

Танай “дургун” хэмээх хил дамнан малын хулгай, панз наймаа хийдэг цөөн хүмүүс байдаг. Үнэн хэрэг дээрээ эдгээр ардууд бол хүчтэй, ухаантай, сэргэлэн хүмүүс бөгөөд тэднийг зөв чиг голдрилд оруулах, хүч ухааныг зөв зүйлд ашиглах хэрэгтэй юм шиг надад санагдаж байна. Тэд зах зээлд юу хэрэгтэй, хаанаас авахыг маш сайн мэддэг, тодруулбал монголчуудад юу хэрэгтэйг Оросын том зах зээлээс хаанаас ч олж ирэх чадвартай хүмүүс юм.

Ярианыхаа төгсгөлд Монголын төлөөлөгчдийн тэргүүн Б.Чадраа Тувагийн засгийн газрын дарга Ш.Д.Ооржакад элэгсэг дотно хүлээн авч, хоёр орны харилцаа хамтын ажиллагааны талаар илэн далангүй ярилцсанд талархал илэрхийлэв.

Энэхүү уулзалтын дараа манай төлөөлөгчдийг Бүгд Найрамдах Тува улсын Их хурлын Төлөөлөгчдийн танхимын дарга Дандар-оол Кок-Хунаевич Ооржак хүлээн авч уулзав. Д.К.Ооржак Тувагийн өмнөх Үндсэн хууль ОХУ-ын Үндсэн хуультай бага зэрэг зөрчилдөж байсан. Энэ талаар урьд өмнө үндсэн хуулиудын зөрчил тэмцэл гэж олон удаа бичиж ярьж байсан, энэ талаар багагүй судалгаа хийсэн юм. Энэ бүхний эцэст 2001 онд манай улс шинэ Үндсэн хуультай болсон билээ. Энэ шинэ Үндсэн хуулийн дагуу энэ оны 6-р сарын 2-нд хоёр танхим бүхий Их хурлын сонгуулийг анх удаа явуулав. Их хурлын Дээд танхим болох Төлөөлөгчдийн танхим нь 130 депутаттай, доод танхим буюу байнгын ажиллагаатай Хууль тогтоох танхим 32 депутатаас бүрдэх юм. Одоогоор зөвхөн Төлөөлөгчдийн танхим бүрэлдээд даргаа сонгоод байгаа, харин Хууль тогтоох танхим хараахан бүрэлдэж чадаагүй, дахин сонгууль явуулсны дараа бүрэлдэж дуусах юм. Хууль тогтоох танхимын даргын сонгуульд нэр дэвшигч нарын аль ч одоогоор хангалттай санал авч чадаагүй тул дахин сонгууль хүртэл дарга нь сонгогдож чадахгүй байна.

Б.Чадраа хариу үг хэлэхдээ тувагийн ард түмэн хэл, соёл, нутаг усаа цэвэр онгон байдлаар авч үлдэж, хадгалсаар өнөөг хүрч чадсан нь их чухал юм. Хөрш орнуудын хувьд бид нягт хамтран ажиллах хэрэгтэй. Нөгөө талаар Тува ОХУ-ын бүрэлдхүүнд багтан нийгэм эдийн засгаа хөгжүүлж байгаа болон манай хоёр орны ард түмнийг холбох гүүр болж буйгаараа бид бас их хувь заяатай хэмээн бодож байна.

Мөн өдрийн үдээс өмнө манай төлөөлөгчид Кызыл хотноо сууж буй Монгол улсын Ерөнхий консулын газарт зочлох үеэр консул Д.Пунцаг ЕКГ-аа хэрхэн байгуулж, тохижуулсан, өнөөгийн ажил байдал хэрхэн явагдаж буй талаар танилцуулав.

2002 оны 8-р сарын 15-ны үдээс хойш манай төлөөлөгчид Тувагийн улсын их сургуулиар зочлов. ТУИС-ийн ректор Н.Г.Дубровский сургуулийнхаа түүхэн замнал, өнөөгийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааныхаа талаар товч танилцуулав. ТУИС анх 1952 онд Кызыл хотын багшийн коллеж нэртэйгээр байгуулагдаж, удалгүй 1956 онд Тувагийн Улсын багшийн дээд сургууль болсон ажээ. Харин 1995 онд ОХУ-ын засгийн газрын шийдвэрээр ТУИС болсон бөгөөд одоо 300 гаруй багш ажилтнууд, 3000 орчим оюутнуудтай, 20 гаруй мэргэжлээр сургалт явуулдаг байна. Тус сургууль Оросын болон АНУ, Герман, Монгол, Турк, Хятад зэрэг олон орны их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлдэг байна.

Б.Чадраа сургуулийнхаа ажил байдалтай танилцуулсанд талархал илэрхийлээд Монголын өнөөгийн дээд боловсролын тогтолцоо, Монгол улсын ШУА, монгол дахь орос хэлний сургалт зэрэг асуудлаар товч ярьсаны дараа боловсон хүчин, ялангуяа эрдэмтэн бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, орос хэлний багш мэргэжилтэн урьж ажиллуулах, хамтарсан эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлэх талаар хамтарч ажиллах санал тавьсныг ТУИС-ийн ректор Н.Г.Дубровский талархан хүлээн авч судалж үзэхээр тохиролцов.

Төлөөлөгчид мөн өдрийн үдээс хойш 60 баатрын нэрэмжит Тувагийн орон нутгийг судлах музей үзэж сонирхов.

2002 оны 8-р сарын 15-ны 18.00 цагаас БНУ тунхагласан өдөр, Малчдын өдөр - Наадам-2002 –д зориулсан баярын хурал оролцож, урлагийн мастеруудын концертыг үзэж сонирхов. Хурал гол төлөв орос, тува хоёр хэл дээр явагдсан ба Засгийн газрын дэд даргын үүрэг гүйцэтгэгч, баяр наадмыг зохион байгуулах комиссын дарга Лавриненко хөтлөн явуулав. Хурлын эхэнд Бүгд Найрамдах Тыва (Тува) улсын Засгийн газрын дарга Ш.Д.Ооржак БНУ-ын Засгийн газрын өнгөрсөн нэг жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажил, ололт амжилт саад бэрхшээлийн талаар дэлгэрэнгүй ярьж, нийт ард түмэндээ баярын мэндчилгээ дэвшүүлэв. Хурлын үеэр хөдөлмөр бүтээл, урлаг соёлын амжилтаар тодорсон тэргүүний хүмүүсийг БНУ-ын алдар цол, одон медаль, баярын бичгээр шагнаж урамшуулав. Баярын хурал дээр Монгол улсын Их хурлын гишүүн, ШУА-ийн ерөнхийлөгч Б.Чадраа баяр хүргэж үг хэлэв.

2002 оны 8-р сарын 16-ны өдөр манай төлөөлөгчид Кызыл хотоос урагш 9 км зайтай орших Тос булаг хэмээх газар хурдан морины уралдаан, шилдэг морины эмээл, тоноглолын уралдаан тэмцээнийг үзэж сонирхов. Тувад хурдан морийг ихэд хүндлэн эрхэмлэдэг болох нь тэнд цугларсан олон мянган үзэгч, түрүүлсэн морины бай шагналд автомашин өгч байсан зэргээс тодорхой харагдаж байлаа. Хурдан морийг нас насаар нь, 20-40км зайнаас тавьж уралдуулдаг нь манайхтай их төстэй байв. Үүнээс гадна хурдан морины ихэнх нь бие томтой тоомсог маягийн морьд байсан ба мөн 8 км-ийн тойргоор уралдаж байсан нь бас нэгэн онцлог болж байв. Хүмүүсийн хамгийн сонирхол татсан арга хэмжээ бол шилдэг морины эмээл тоноглол шалгаруулах ёслол байлаа. Эмээлийн хувьд монгол маягийн эмээл тоноглол зонхилж байлаа. Тэдний дунд Тувагийн алс баруун захын Мөнгөн тайгын хошуунаас сарлаг унасан, тарваган дээл өмсч, агнасан 2 том тарвага, загаснуудаа зүүж орж ирсэн хүү олны сонирхлыг маш их татаж байлаа.

2002 оны 8-р сарын 16-ны өдөр ОХУ-ын Бүгд Найрамдах Тыва (Тува) улсын Засгийн газрын дарга Ш.Д.Ооржак БНУ-ын Засгийн газрын ордонд Монгол улсын Их хурлын гишүүн, ШУА-ийн ерөнхийлөгч Б.Чадраа тэргүүтэй төлөөлөгчдийг дахин хүлээн авч уулзан өдрийн зоог барив. Өдрийн зоог үндсэндээ үндэсний хоол шүүсээр бэлтгэсэн нь үндсэндээ монгол маягаар бэлтгэсэн хонины ууц, бүхэл мах, гэдэс, сорс, бууз зонхилж байлаа.

Мөн өдрийн үдээс хойш Тувагийн 3-р эмнэлэг болон түүний дэргэд саяхан шинээр баригдаж ашиглалтанд орсон Кызыл хотын Бөөрний төвөөр зочилж ажил байдалтай танилцав. Эмнэлэг, бөөрний төвтэй танилцах үеэр Тувагийн эрүүл мэндийн яамны сайд Л.С.Эрдыниева дагалдан явав. 3-р эмнэлгийн ерөнхий эмч Дыртыи-оол Урана Амырдиевна эмнэлгийн, ялангуяа шинээр байгуулагдсан Бөөрний төвийнхөө эмчилгээний хүчин чадал, тоног төхөөрөмжийнхөө үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй тайлбарлан үзүүлж, нэгэнт суурилуулсан хиймэл бөөрний тав, диализ буюу цус цэвэршүүлэх таван аппаратыг бүрэн хүчин чадлаар ашиглахын чухлыг онцлон дурьдаж байлаа. Хамгийн орчин үеийн техникээр тоноглогдсон эмнэлэг Монголын хил орчмын аймгуудын хүн ардыг эмчлэхэд бэлэн байгаа болон эмчилгээний үнэ өртөг, олон улсын түвшингээс төдийгүй Москва болон бусад том хотуудаас ч ихээхэн доогуур байгаа тухай тэмдэглэлээ. Б.Чадраа энэ хүсэл сонирхлыг ихээхэн дэмжин сайшааж, өмнөд хөрш Хятад улс зах зээлээ мэдрэн угтан ажиллах талаар их идэвхитэй ажилласныг Хятадын Эрээн хотын жишээг татан яриу. Цаашид эмнэлэг

эрүүл мэндийн салбарт идэвхитэй хамтран ажиллах бүрэн боломж байгааг нэн даруй ашиглаж эхлэх идэвхи санаачлага аль аль талдаа хэрэгтэй байгааг онцлон тэмдэглэв. Өөрийн зүгээс энэ талын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бололцооныхоо хэрээр тус дэмжлэг үзүүлэх, эмнэлэг хоорондын шууд хамтын ажиллагааг хөгжүүлэхэд туслалцаа үзүүлнэ гэдгээ амласан байна.

Үүний дараа манай төлөөлөгчдийг Тувагийн улсын лицейг үзүүлэв. Энэ сургууль 1990 онд байгуулагдсан, тус улсын хамгийн авьяаслаг хүүхдүүдийг тусгай програмаар сургадаг улсын сургууль ажээ. Эндхийн сургалт өндөр түвшинд судалгаатай хослуулан явуулдаг тул төгссөн хүүхдүүд зуун хувь их дээд сургуульд элсэн ордог янз бүрийн олон улсын болон холбоот улсын хэмжээний уралдаан тэмцээнээс олон медаль, шагнал хүртдэг байна. Монгол улсын ижил төстэй байгууллагатай хэлхээ холбоо тогтоох, түүний дотор монгол хэлний анги нээж, уйгаржин монгол бичигтэй судлаач бэлтгэхээр төлөвлөж байгаагаа танилцуулав. Их хурлын гишүүн Б.Чадраа энэ саналыг дэмжин сайшааж, Монгол улсын хувьд ч сүүлийн үед орос хэлний сургалт ихэд суларсан тул харилцан багш, сурагчид солилцвол ихээхэн үр дүнтэй харилцан ашигтай арга хэмжээ болно хэмээн бодож байгаагаа илэрхийлэв. Хэрэв тувагийн тал санал хүсэлт гаргавал Монголын холбогдох сургуультай хэлхээ холбоо тогтооход дэмжлэг туслалцаа үзүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлэв.

Мөн өдрийн үдээс хойш манай төлөөлөгчид Кызыл хотын биеийн тамир спортын төв цогцолборт тувагийн үндэсний бөх-хурешийг Засгийн газрын дарга Ш.Д.Ооржакийн хамт үзэж сонирхов. Бөх бол тува нарын хамгийн үзэх дуртай үндэсний спортын нэг төрөл бөгөөд үндсэндээ барилдааны арга техник, өмсгөл, дүрэм монгол үндэсний бөхтэй бараг адил боловч зарим нэг онцлогуудтай. Тухайлбал, урьд хэрэглэж байсан одоогоор арслан, заан, начин цолоо хараахан сэргээгүй байгаа, гар газарт хүрвэл унасанд тооцох, тахим авах өгөхийн оронд гар барьдаг, ам авдаггүй шууд сугалж барилддаг зэрэг болно. Түрүүлсэн бөхийг шууд шинэ автомашинаар байлдаг бөгөөд насанд хүрэгчид ба өсвөр үеийнхэн гэсэн насны хоёр ангиллаар барилдааныг явуулдаг. Монголын бөхчүүдийг маш сайн мэддэг, монгол бөхчүүд ирвэл тэмцээн наадмыг ихээхэн сонирхолтой болгодог хэмээн ярьж байв.

Барилдааны дараа төлөөлөгчид Цэцэнлин хэмээх буддын сүмийг үзэж сонирхов. Тува нар эрт дээр үеэс буддын шашныг шүтэн биширч ирсэн бөгөөд монголчуудтай сүсэг бишрэлийн ихээхэн

барилдлагатай байсан юм. Учир нь Тувагийн сүм дуган дахь дээд зэрэглэл нь хамба лам байсан бөгөөд тувагийн сүсэгтнүүд гол төлөв Монголын хутагт хувилгаадын шавь болж байв. Сүүлийн жилүүдэд, 1990 оноос хойш Тувад буддын шашин ихэд түгэн дэлгэрч нутгийн ард олны ахуй заншилд шашны зан үйл чухал үүрэг гүйцэтгэж байгааг энэ сүмийг шинээр байгуулж ажиллуулж байгаа байдлаас тодорхой харагдаж байв. Төвдийн Далай лам Тувад 3 удаа зочилсон нь сүсэг бишрэл нэмэгдэхэд эерэгээр нөлөөлсөн ажээ. Энэ өдрийн бүхий л арга хэмжээнд Тувагийн боловсролын сайд Э.О.Морозов дагалдан явж оролцов.

2002 оны 8-р сарын 17-ны өдөр манай төлөөлөгчдөд Кызыл хотоос хойш 200 гаруй км –т байгаа “Аржаан” хэмээх эртний булш бүхий хөндийг үзүүлсэн юм. 1990-ээд оны дундуур эндээс Тувагийн нутагт МЭӨ- 5-7 зууны үед амьдарч байсан овог аймгуудын язгууртнуудын томоохон булшны газар илрүүлсэн ажээ. Эдгээр булшийг Германы талын санхүүжилтээр Орос, Тувагийн эрдэмтэд хамтран малталт хийж үндсэндээ дуусгасан ба одоо нарийвчилсан судалгаа хийхээр Санкт-Петербург руу ихэнх олдворыг аваад явсан байна. Эрдэмтдийн урьдчилсан таамаглалаар эдгээр булш нь Скифийн үед хамаарах, харьцангуй бүтнээрээ олдсон эрдэм шинжилгээний хувьд нэлээд үнэт археологийн олдворт тооцож байгаа ажээ. Энд эртний булшийг хулгайгаар ухах, олдворыг авч явах зэрэг сөрөг үзэгдэл байнга гардаг тул харуул хамгаалалттай болгох, үндэсний түүх дурсгалын газар-музей байгуулах, аялал жуулчлалын төв болгох санал төлөвлөгөө байгаа ажээ.

Манай төлөөлөгчид энэ өдөр Саяны нурууны гол даваа хүртэл аялан орон нутгийн байгалийн үзэсгэлэнг үзэж сонирхов.

2002 оны 8-р сарын 18-ны өдрийг бүхэлдээ Тувагийн үйлдвэр аж ахуйн газруудтай үзэж танилцах, холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар санал солилцоход зориулагдсан байлаа. Энэ өдрийн өглөө Каа-Хэмийн нүүрсний ил уурхайд зочлов. Тус улсын нүүрсний хэрэгцээг хангадаг гол уурхайн даргаар Тен Ен Так хэмээх солонгос гаралтай бизнесмэн удирддаг бөгөөд үйлдвэрийнхээ ажил байдлын талаар товч танилцуулав. 1990 онд тус улс 1 сая тонн нүүрс олборлож байсан бол эдүгээ 520 гаруй мянган тонныг олборлож байна. Төмөр замгүй тул нүүрс олборлолт, тээвэрлэлтэнд тодорхой хэмжээгээр сөрөг нөлөөлдөг ажээ. Тус уурхай Монгол улстай хамтран нүүрсний ил уурхай нээж ашиглах, холбогдох уул уурхайн тоног төхөөрөмж сэлбэг нийлүүлэх зэрэг хэлбэрээр

хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлэв. Монгол улсын Их хурлын гишүүн Б.Чадраа өөрийн сонгогдсон тойрог болон Архангай аймаг нүүрсний хангалт сайнгүй нэлээд зардал гарган холоос тээж авчирдаг тул тэнд бэлэн байгаа нүүрсний бага, дунд хэмжээний нүүрсний ил уурхайг нээж ашиглах, монголын талын сонирхож буй зарим тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нийлүүлэх, ижил төстэй компанитай харилцаа тогтооход тус дэмжлэг үзүүлэх зэрэг нэлээд хэдэн ажил хэрэгч санал дэвшүүлснийг уг уурхайн удирдлага сонирхож хүлээн авав. Нөхцөл байдлыг газар дээр нь очиж судалж үзэхээр хоёр тал тохиролцов.

Үүний дараа төлөөлөгчид “Тувинские ковры” ГУП /государственное унитарное предприятие/ улсын үйлдвэрийн газарт ихээхэн ажил хэрэгч уулзалт хийв. Уг үйлдвэрийн ерөнхий захирал Буян Богбалдайович Ооржак манай төлөөлөгчдийг хүлээн авч уулзан үйлдвэрийнхээ ажил байдал, бүтэц зохион байгуулалт, ирээдүй төлөвийн талаар товч танилцуулав. Тус компани нь 4 үйлдвэрээс бүрдэх бөгөөд гол хоёр салбар бол нэхий боловсруулах үйлдвэр, хивсний үйлдвэр ажээ. Одоогоор үйлдвэрийн нийт хүчин чадлынхаа ердөө 10% буюу 30-35 мянган ширхэг нэхий боловсруулж байгаа ба Тува нийтдээ 600 мянган толгой хоньтойгоос жилд 100 гаруй мянган нэхий гарах боломжтой боловч зах зээлийн өрсөлдөөний улмаас тус үйлдвэр худалдан авах бололцоо муутай байдаг. Нэхийний нэлээд хэсгийг шууд Хятад руу гаргадаг. Иймд Монголоос бараа солилцоогоор түүхий эд авах, боломжтой бол малыг амьдаар авах хүсэлтэй байгаа хэмээн ярих. Энэ чиглэлээр тус үйлдвэр нэлээд ажил хийгээд байгаагийн дотор Финляндаас нүүдлийн мал нядалгааны цехийг оруулж ирсэн байна. Монголын хэд хэдэн компанитй худалдаа, хамтын ажиллагааны гэрээтэй ажилладаг, мөн Улаангомд өөрийн төлөөлөгч суулгадаг тухай ярьж байв. Ноосны хувьд тувагийн хонь гол төлөв нарийвтар ноостой байдаг бол Монгол хонь бүдүүн, бүдүүвтэр ноостой, хивс үйлдвэрлэхэд хамгийн тохиромжтой хэмээн үздэг байна. Өнгөрсөн жил тус үйлдвэр Монголоос 180 тонн ноос авснаас 80 тоннийг өөрсдөө боловсруулж, 100 тонн транзит худалдаагаар арилжсан байна. Цаашид ноос, нэхий импортлох нь ихээхэн ирээдүйтэй боловч янз бүрийн бэрхшээл багагүй байгааг ерөнхий захирал дурьдсан юм. Жишээ нь танай баруун аймгуудад энэ намар шүлхий өвчин гарсны улмаас мал аж ахуйн гаралтай бүх түүхий эдийг импортлохыг хориглоод байна. Төлбөр тооцооны асуудал ч бас байна. Одоогоор хоёр талд ашигтай хэлбэр бол бараа солилцоо болоод байна. Увс, Завханаас тус бүр 500т гурил

авах санал ирээд байна. Цагаан толгойн боомтын ойролцоо анхан шатны ноос боловсруулах цех хамтран байгуулах ажил ч мөн хэлэлцэгдэж байна. Иймэрхүү бизнес төлөвлөгөөг сайтар бодож боловсруулж хийх хэрэгтэй байна. Хэдийгээр манай тал Оросын Арзамас, Черногорын үйлдвэр аж ахуйн газруудтай тоног төхөөрөмж нийлүүлэх, бараа түүхий эд борлуулах талаар тохиролцон эхний ээлжинд машин тоног төхөөрөмж авчирсан боловч янз бүрийн шалтгаанаар уг ажил хэрэгжиж чадалгүй хойшлогдоод байна.

Манай төлөөлөгчдийн тэргүүн Б.Чадраа хоёр талын харилцан сонирхож буй хамгийн ирээдүйтэй чиглэл бол мал аж ахуйн гаралтай түүхий эд, хүн амын өргөн хэрэгцээний бараа, машин техникийн худалдаа гэдгийг онцлон тэмдэглээд энэ салбарт хамтын ажиллагааны их ирээдүй байна. Юуны өмнө чөлөөт худалдааны бүсийг нэн даруй байгуулж, яармаг худалдааг тогтмолжуулах хэрэгтэй. Ноос, нэхий, мах гэх мэт мал аж ахуйн бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалт хийх чиглэлээр хамтран ажиллавал үр дүн сайн, зарим саад бэрхшээл, тухайлбал тээврийн зардал буурах, мал эмнэлгийн хяналт, хорио цээрийн хязгаарлалтанд өртөх нь багасна. Нөгөө талаас Архангай аймагт ийм цех байгуулбал ус, цахилгаан, түүхий эд, ажиллах хүч байна, зөвхөн хоёр талаас идэвхи санаачлага, төр засгийн хүчтэй дэмжлэг хэрэгтэй юм.

Бас нэг сонирхол татаж болохуйц мал бол сарлаг бөгөөд сүүгээр нь маш сайн чанарын цөцгийн тос, сыр гаргаж авах боломжтой. Мөн сарлагийн хөөвөр гэж ашиглаж чадвал сайн чанарын чухал түүхий эд байна. Энэ талаар хэрэв танай тал сонирхож байвал бид танайд тохирох найдвартай түнш олж өгөхөд тусалж чадна.

Б.Ооржак бидэнд оросын үйлдвэрүүдтэй тохиролцсон зүйлүүд ч бий, зарим тоног төхөөрөмжийг энд авчраад ирсэн хэмээн яриад зам тээврийн асуудлыг судалмаар байна гэв. Б.Чадраа одоо манай улсад хэрэгжүүлж буй Мянганы зам төслийн дагуу гол гол даваа нугачааг засч байгаа, ойрын ирээдүйд засмал зам тавихаар төлөвлөж байгаа. Харин хил хүртэл зам тавих асуудал энэ төсөлд бүрэн тусаагүй тул энэ талаар манай танай хоёр тал хамтран ажиллавал үүнийг шийдвэрлэх боломжтой юм хэмээн хэлэв. Мөн одоо хийж буй бараа солилцооны жишиг үнийг сонирхоход үйлдвэрийн дарга Б.Ооржак 1 кг угаасан ноосыг 1-р зэргийн 1.20 кг гурилаар сольж байна. Хамгийн хялбар эхэлж болох чиглэл мал нядлах, мах боловсруулах цех байгуулах явдал бөгөөд тоног төхөөрөмж нь бэлэн байна гэв. Мөн нэхийг нь шууд импортолж болно. Нэг нэхий манай зах зээл дээр 50 рубль хүрч байна.

Б.Чадраа үнэ ханшийн хувьд боломжийн юм байна. Эцэст нь бас нэг санал байна. Манайд чоно их элбэг тул түүнийг агнаад арьсыг нь экспортлох их боломж байна. Танайд ч гэсэн түүнийг авах зах байгаа гэж бодож байна.

Б.Ооржак манай сибирь их хүйтэн, урьд өмнө чонын арьсаар хийсэн дах, дэгтий хэрэглэж байсан. Хэрэв сайн судалбал энэ бизнест ч ирээдүй бий. Ингээд хоёр тал харилцан сонирхож буй асуудлуудаа цаашид гүнзгийрүүлэн судалж зарим ажлуудыг энэ жилээс хэрэгжүүлж эхлэхээр тохиролцов.

Манай төлөөлөгчид энэ өдөр Тувад бизнесийн талаар нэлээд нэр нөлөө бүхий алтны “Ойна” артелиар зочлов. “Ойна” артель Монголд хөрөнгө оруулах талаар судалгааны ажлаа эхлээд байгаа. Хоёр тал цаашид энэ ажиллагаагаа идэвхижүүлэхээр тохиролцов.

2002 оны 8-р сарын 19-ний өглөө Монгол улсын Их хурлын гишүүн, ШУА-ийн ерөнхийлөгч Б.Чадраа тэргүүтэй Монголын хүндэт зочдыг Тува (Тыва) улсын Засгийн газрын дарга Ш.Д.Ооржак Кызыл хотоос 40 гаруй км өөрийн биеэр дагалдан явж үдэн гаргаж өгөв. Үдэн гаргахад Ерөнхий болон мэргэжлийн боловсролын сайд Э.О.Морозов, Эрчим хүч, зам, тээврийн сайд С.В.Никонов, Гадаад хөрөнгө оруулалт, гадаад эдийн засгийн яамны сайд Хеймер-оол Кокович Куулар, дэд сайд Н.Ч.Дариймаа, тус яамны ажилтан Мэргэн, Каа-Хэмийн уурхайн дарга Тен Ен Так, “Ойна” артелийнхан байлцав. Манай төлөөлөгчдийг Эрчим хүч, зам, тээврийн сайд С.В.Никонов, Гадаад хөрөнгө оруулалт, гадаад эдийн засгийн яамны сайд Хеймер-оол Кокович Куулар, дэд сайд Н.Ч.Дариймаа, тус яамны ажилтан Мэргэн нар хилийн боомт Цагаан толгой хүртэл дагалдан явав.

Цагаан толгой-Арцсуурийн боомт дээр очих замдаа Монгол улсын Их хурлын гишүүн, ШУА-ийн ерөнхийлөгч Б.Чадраа энэ хэсэгт худалдааны чөлөөт бүс байгуулах боломж нөхцөл, зам харилцааны байдлыг Эрчим хүч, зам, тээврийн сайд С.В.Никонов, Гадаад хөрөнгө оруулалт, гадаад эдийн засгийн яамны сайд Хеймер-оол Кокович Куулар, дэд сайд Н.Ч.Дариймаа нартай нэлээд нухацтай ярилцаад эхний ээлжинд Тувагийн талаас Монгол-Оросын хил хүртэлх 50 гаруй км замыг хатуу хучилттай болгох, манай хилийн боомт Арцсуурийг тувагийн талаас цахилгаан авах боломжийг бүрдүүлэхээр тохиролцов. Цаашид зам тавих талаар хамтран ажиллах боломж нөхцөлийг судлахаар тогтов.